



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/198

Мандалговь

“Геомеп” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Газар усны нэр тодруулах (Гурвансайхан, Сайнцагаан, Говь-Угтаал, Өндөршил, Луус, Дэрэн)” зөвлөх үйлчилгээний багц-3 (Дэрэн сум, Говь-Угтаал сум)-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Геомеп” ХХК-тай 19,135,555 (арван есөн сая нэг зуун гучин таван мянга таван зуун тавин тав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Газар усны нэр тодруулах (Гурвансайхан, Сайнцагаан, Говь-Угтаал, Өндөршил, Луус, Дэрэн)” зөвлөх үйлчилгээний багц-3 (Дэрэн сум, Говь-Угтаал сум) ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Геомеп” ХХК-ийн захирал (Ю.Чүлтэм)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Дэрэн сумын Засаг дарга (Н.Мядагмаа), Говь-Угтаал сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060782